



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 1/217

Арвайхээр

┌ Хүн ам орон сууцны 2020 оны тооллогын ┐
аймгийн түр товчоо сумдын комисс, байгуулж
ажиллуулах тухай


Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт, Хүн ам, орон сууцны тооллогын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, Хүн ам, орон сууцны тооллогын Улсын комиссын 2018 оны “Аймаг, нийслэлийн тооллогын комиссын бүрэлдэхүүн томилох тухай” 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн ам, орон сууцны тооллогын аймгийн комиссын удирдлаган дор тооллогын бэлтгэл ажлыг ханган, тооллогын ажлыг зохион байгуулах аймгийн түр товчооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хүн ам орон сууцны 2020 оны ээлжит тооллогын ажлыг зохион байгуулж явуулах сумын тооллогын комиссын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сум, багийн тооллогын түр товчоог сумын Засаг даргын захирамжаар байгуулж, хүн ам, орон сууцны ээлжит тооллогын бэлтгэл ажлыг ханган, тооллогыг чанартай зохион байгуулж, тооллогын нөхөгдсөн асуулгын хуудас, урьдчилсан дүн, бусад материал, илтгэх хуудас зэргийг тогтоосон хугацаанд багтаан Статистикийн хэлтэст ирүүлэхийг сумдын тооллогын комиссын дарга нарт даалгасугай.


3. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогыг мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар ханган, ажлын явц байдалд хяналт тавьж, тооллогын дүн материалыг хүлээн авч нэгтгэх, улсын тооллогын комисст хүлээлгэн өгөх ажлыг хугацаанд нь зохион байгуулахыг аймгийн түр товчооны дарга, Статистикийн хэлтсийн дарга (О.Түмэнжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

Аймгийн Засаг даргын 2018 оны ...04...
дүгээр сарын 13-ны өдрийн 4217 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



АЙМГИЙН ТҮР ТОВЧООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Түр товчооны дарга: О.Түмэнжаргал -Статистикийн хэлтсийн дарга
Түр товчооны орлогч дарга: Ц.Должинсүрэн -Статистикийн хэлтсийн ахлах
мэргэжилтэн

Гишүүд: Х.Мөнхцэцэг -Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

Э.Өүлэн -Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

Д.Чулуунцэцэг -Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

Х.Нямцэрэн –Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн мэргэжилтэн

П.Мөнхзул -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Э.Энхбаяр -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн
сангийн хэлтсийн мэргэжилтэн


С.Мягмарсүрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх Улсын бүртгэлийн
хэлтсийн улсын бүртгэгч

Р.Уранчимэг -Эрүүл мэндийн газрын статистик мэдээ хариуцсан
ажилтан

С.Зоригтбаатар –Аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа,
барилга, хот байгуулалтын газрын геодези, зураг зүй
хариуцсан мэргэжилтэн

-oOo-

Аймгийн Засаг даргын 2018 оны 04
дүгээр сарын 13-ны өдрийн 1/217 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



СУМЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Тооллогын комиссын дарга: - Сумын Засаг дарга

Тооллогын комиссын орлогч дарга: -Сумын Засаг даргын орлогч

Гишүүд: -Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга

-Засаг даргын Тамгын газрын дарга

-Санхүүгийн албаны дарга

- Иргэний бүртгэлийн ажилтан

-Төрийн захиргааны түшмэл

-Эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч

-Ерөнхий боловсролын сургуулийн захирал

-Газрын даамал /байгаль орчны байцаагч/

-Цагдаагийн хэсгийн төлөөлөгч

Нарийн бичгийн дарга: -Статистик хариуцсан ажилтан

-oOo-